

Санхүүгийн хяналт шалгалт
хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын 2021 оны 11 сарын 11-ны өдрийн 1/21 тоот удирдамж аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Могод сумын Эрүүл мэндийн төвийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, боловсролын холбогдох хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Л.Цэрэнбүтэд 2021 оны 11 дүгээр сарын 14-ээс хуанлын 6 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Эрүүл мэндийн төвийн 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, тэтгэмж, шагнал урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Могод сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн А/01 тоот тушаалаар Эрүүл мэндийн төвийн нь дарга 1, нягтлан бодогч 1, их эмч 1.5, эх баригч 1, ахлах сувилагч 1, сувилагч 4, нийгмийн эрүүл мэндийн сувилагч 1, багийн бага эмч

1, лаборант 1, эрүүл мэндийн статистикч, бага эмч 1, жолооч 1, нярав, бичиг хэрэг 1, тогооч 1, үйлчлэгч 4 нийт 23.5 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Тус эмнэлгийн 1-р гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-ээс 12 сарын 31-нийг дуустал хугацаанд эрхлэгч Г.Булган, хоёрдугаар гарын үсгийг 2021 оны 1 сарын 1-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд нягтлан бодогч Н.Дэлгэр нар зурж, төрийн санд бүртгэлийн 100040620001 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100040620401 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитаар 2021 оны санхүүгийн тайланд нийцлийн аудит хийж зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Төрийн аудитын 01/74 Буа-2022/53/НА-СТА-ТШЗ тоот төлбөрийн актаар тэтгэмж урамшууллын зардлыг түүвэрлэн шалгахад 400.0 мянган төгрөгийн тэтгэмжийг тушаал шийдвэргүйгээр олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13 дугаар 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тушаал шийдвэргүйгээр олгосон 400.0 мянган төгрөгийг Төрийн аудитын газрын дансанд 2022 оны 05 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэхийг хариуцуулсаныг хугацаанд нь барагдуулсан байна.

Төрийн аудитын 02/75 Буа-2022/53/НА-СТА-ТШЗ тоот төлбөрийн актаар 2021 эмийн орлого, зарлагыг түүвэрлэн шалгахад 368.0 мянган төгрөгийн эмийн орлого дутуу, илүү шилжүүлсэн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” НББ-ийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, гэсэн заалтуудыг зөрчсөнд 368.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн аудитын дансанд 2022 оны 05 дугаар сарын 15-ны төвлөрүүлэхээр дарга, нягтлан бодогчид хариуцуулсанг хугацаанд нь барагдуулсан байна.

Төрийн аудитын 01/58 Буа-2022/53/НА-СТА-ТШЗ албан шаардлагаар 2021 оны бараа материалын тодруулга тайлангийн эмийн зарцуулалтын орлого, зарлагын дүнг харилцагч байгууллагын нэхэмлэх дүнгээр түүвэрлэн шалгахад 926.3 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, үлдэгдэлийн тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн туха хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 2.6-д “эд хөрөнгийн болон төлбөрийн болон төлбөр

тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо нийлж, үлдэгдэлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага бичиж хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна.

ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны нэгдсэн сайтад тус сургууль 2021 онд мэдээлбэл зохих 161 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд мэдээлж 11 мэдээлэлийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

ДОЛОО. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Тус эмнэлгийн 2021 оны касс, харилцах, аж ахуйн баримт, өмч хөрөнгийн бүртгэл, байгууллагын удирдлагын гаргасан шийдвэр, хөдөлмөрийн дотоод журам, цалингийн карт, ажлын цаг ашиглалтын бүртгэл, хүнсний агуулахын бүртгэл, дуудлагын журнал, эмийн захиалга, тооллогын бүртгэл, агуулахын бүртгэл, санхүүгийн тайлан зэрэг баримт материалуудад тулгуурлан нягтлан бодогч, Б.Ичинхорол, Н.Дэлгэр, нярав Л.Ганганмөрөн нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

8.1.Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2021 онд улсын төсвөөс 386549.3 мянган төгрөгийн санхүүжилт, ковидын оношлуурын мөнгө 3655.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарлагдсан хөрөнгө 209583.4 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилт 62302.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 16736.8 мянган төгрөг нийт 678826.8 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 353086.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 45320.5 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 2170.2 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 30156.2 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 105.5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1251.9 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 13973.3 мянган төгрөг, шуудан, холбооны зардалд 1815.6 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэргэчдийн устгал, ариутгалын зардалд 2783.4 мянган төгрөг, эм бэлдмэлийн зардалд 97555.0 мянган төгрөг, хоол, хүнсний зардалд 6588.1 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 3003.0 мянган төгрөг, багаж техник, хэрэгсэлийн зардалд 730.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1826.5 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 648.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөрт 1006.7 мянган төгрөг, даатгалын үйлчилгээний зардалд 70.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэлийн оношлогоо, татварын зардалд 101.5 мянган төгрөг, мэдээлэл, технологийн үйлчилгээний зардалд 1350.0 мянган төгрөг, газрын төлбөрт 40.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 7757.8 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 22000.0 мянган төгрөг, нэг удаагийн шагнал урамшууллын зардалд 9300.0 мянган төгрөг, хөрөнгө бэлдэхэд 46620.3 мянган төгрөг нийт 583908.0 мянган төгрөг зарцуулж 13343.6 мянган төгрөг үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар: 2021 онд Эрүүл мэндийн газар болон Эрүүл мэндийн даатгалын сангаас 189663.7 мянган төгрөг, ковидын тестээс 3655.0 мянган төгрөг нийт 193318.7 мянган төгрөг дансаар орж цалин шимтгэлийн зардалд 51965.6 мянган төгрөг, шатахууны зардалд 279.2 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 8147.9 мянган төгрөг, эмийн зардалд 47372.8 мянган төгрөг, багаж хэрэгсэлийн зардалд 41510.3 мянган төгрөг, урсгал засварын зардалд 523.5 мянган төгрөг, бусад зардалд 6746.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулын зардалд 30400.0 мянган төгрөг нийт 186945.2 мянган төгрөг зарцуулж 6373.5 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар: Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 4 сарын 22-ны өдрийн Б/08 тоот тушаалаар 21 эмч, эмнэлгийн ажиллагсадад 36-46 %-аар 1-р улирлын үр дүнгийн урамшуулалд 6082.4 мянган төгрөг, 06 сарын 26-ны өдрийн Б/10 тоот тушаалаар 21 эмч эмнэлгийн ажиллагсадад 2-р улирлын үр дүнгийн урамшуулалд 42-45 %-аар 5947.7 мянган төгрөг, 10 сарын 25-ны өдрийн Б/14 тоот тушаалаар 21 эмч, эмнэлгийн ажиллагсадыг 3-р улирлын урамшуулалд 39-45 %-аар 5414.2 мянган төгрөг, 12 сарын 15-ны өдрийн Б/19 тоот тушаалаар 18 эмч, эмнэлгийн ажиллагсадад 4-р улирлын урамшуулалд 5042.7 мянган төгрөг, 08 сарын 18-ны өдрийн Б/12 тоот тушаалаар коронавируст халварын үед голомттой бүсэд ажилласан 22 эмч ажиллагсадад буцалтгүй тусламж тус бүр 1000.0 төгрөг бүгд 22000.0 мянган төгрөг, 10 сарын 25-ны Б/15 тоот тушаалаар коронавирус халдварын үед ажилласан 21 эмч эмнэлгийн ажиллагсад тус бүр 400.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж бүгд 8400.0 мянган төгрөг, 12 сарын 13-ны өдрийн Б/17 тоот тушаалаар сумын хэмжээнд гарсан ковид 19 халдварт өвчний тохиолдлуудыг эмчлэх, сувилж улаан бүсэд ажилласан, тэдгээрийн хавьтлуудын тандалт судалгаа хийсэн, шинжилгээ хийсэн, ариутгал халдваргүйтэл хийсэн, хог хаягдал ангилан зөөвөрлөж устгасан, ойрын хавьталуудыг тусгаарлан ажиглах байранд ажилласан болон бусад үйлчилгээг үзүүдсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчидад ажлын ачаалал онцлог зэргийг харгалзан 500.0-1000.0 төгрөг нийт 16600.0 мянган төгрөг нийт 69487.0 мянган төгрөг олгосон байна.

Сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Б/16 тоот захирамжаар 1 дүгээр улирлын урамшуулал 43%-аар 354.9 мянган төгрөг, 07 сарын 26-ны өдрийн Б/23 тоот захирамжаар 2 дугаар улирлын урамшуулал 47%-аар 388.0 мянган төгрөг, 12 сарын 16-ны өдрийн Б/31 тоот захирамжаар 4 дүгээр улирлын урамшуулалд 45%-аар 371.5 мянган төгрөг, 12 сарын 16-ны өдрийн 2021 оны жилийн эцсийн ажлын үр дүнг үнэлж байгууллагын гүйцэтгэлийн биелэлтийн үнэлгээг харгалзан нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 40%-аар 330.2 мянган төгрөг, 11 сарын 01-ны өдрийн Б/28 тоот захирамжаар 9 сарын 1-ээс 12 сарын 31 –ныг хүртэлх хугацаанд сар бүр ур чадварын нэмэгдэл 25%-аар 825.5 мянган төгрөг 2270.1 мянган төгрөг олгосон байна.

8.2 Өглөг, авлагын талаар: 2021 онд өглөггүй, 54355.2 мянган төгрөгийн авлагатай /Эрүүл мэндийн даатгалын сангаас/ тайлан гаргасан байна.

8.3.Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: 2021 оны эхэнд барилга байгууламж 504584.9 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 69090.7 мянган төгрөг, тоног төхөөрөмж 72712.3 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 25155.9 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 12120.0 мянган төгрөг, програм хангамж 300.0 мянган төгрөг, бусад биет хөрөнгө 19204.0 мянган төгрөг нийт 703167.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байсанаас тоног төхөөрөмжид төсвийн хөрөнгөөр Эрхт түшиг ХХК-аас хөлдөөгч 650.0 мянган төгрөг, мотор 650.0 мянган төгрөг, Цомбонгранд ХХК-аас гар

ариутгагч 200.0 мянган төгрөг, Си Ти Эс ХХК-аас Нр 120 принтер 500.0 мянган төгрөг, компьютер 3000.0 мянган төгрөг, Ач есөн эрдэнэ ХХК-аас нярайн инкубатор 7800.0 мянган төгрөг, билиметр 3500.0 мянган төгрөг, дефибрилятор 4500.0 мянган төгрөг, пульсоксиметр 4 ширхэг 45.0 мянган төгрөг, өндөр жин хэмжигч 5 ш 275.0 мянган төгрөг, дуслын хөл 10 ш 95.0 мянган төгрөг, отсос 470.0 мянган төгрөг, Си Энд Эн трейдинг ХХК-аас өвчтөний ор 10 ш 800.0 мянган төгрөг, Юу Жи Ди центр ХХК-аас зүрхний цахилгаан бичлэг 5000.0 мянган төгрөг, хатаах шүүгээ 2000.0 мянган төгрөг, үзлэгийн ор 2 ш 300.0 мянган төгрөг, ургийн доплер 370.0 мянган төгрөг нийт 46620.3 мянган төгрөгийн хөрөнгө, хандиваар Эрүүл мэндийн газраас тавиурын автомат шахуурга, дуслын автомат шахуурга, вакцины хөргөгч суурин компьютер 3 ширхэг нийт 9474.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэж 56095.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж 759263.1 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

8.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт: 2021 оны эхний үлдэгдэл эм боох материал 8091.2 мянган төгрөг, бичиг хэргийн материал 1729.7 мянган төгрөг, аж ахуйн материал 9011.1 мянган төгрөг, сэлбэг 2636.5 мянган төгрөг, хүнсний материал 2592.5 мянган төгрөг, бусад хангамжийн материал 6785.9 мянган төгрөг нийт 30847.0 мянган байсанаас төсвийн хөрөнгөөр 62933.9 мянган төгрөгийн эм боох материал, 2941.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 26719.5 мянган төгрөгийн аж ахуйн материал, 735.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 14593.6 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 6614.6 мянган төгрөгийн хүнсний материал, 34698.4 мянган төгрөгийн бусад хангамжийн материал нийт 148217.2 мянган төгрөгийн материал худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас 181665.9 мянган төгрөгийн үнэгүй эм, вакцин, хандиваар бээлий 1500.0 мянган төгрөг, аж ахуй материалд 1000.0 мянган төгрөг, хүнсний материал мах 1462.5 мянган төгрөг, бусад хангамжийн материалд ЭМГ-аас эмнэлгийн эм хэрэгсэл нийт 30289.1 мянган төгрөг нийт 360192.2 мянган төгрөгийн материал орлогодож 270897.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж 120142.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

ЕС. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Шатахууны тайланд 2021 оны 11 сарын шатахууны үлдэгдэлээс 30 л 69000 төгрөгийн А 92 бензинийг анхан шатны баримтгүй зарлагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.7.-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./, 14 дүгээр зүйлийн 14.3.1-д /анхан шатны баримт бүрдүүлэх;/, 20 дугаар зүйлийн 20.1.1-д /нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;/, 20.1.4-д /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх/

2. Тооллого хийсэн ч шаардлага хангахгүй тооцоо боддоггүй, эд хөрөнгийн карт дутуу бөглөсөн, тооллогын бүртгэлийн маяганд албан хаагч бүрээр тооллогын бүртгэл хөтөлсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.2-т /түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, 72.4.3-д агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг

тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах/, 72.4.4-д / комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх/, 72.2.5-д /эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих/ заасан заалтуудыг тус тус зөрчсөн.

3. Сэлбэгийн тайлан гаргаж архивлаагүй, агуулахын бүртгэлийг буруу хөтөлсөн, шатахуунд агуулахын бүртгэл хөтөлдөггүй нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д /Агуулахын бүртгэл/ хөтлөх зааврыг зөрчсөн байна.

4. Шатахууныг гарсан дүнгээр шууд зарлагддаг жолоочийн тооцоо бодохгүй байгаа нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалаар баталсан Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг нормыг мөрдөж ажиллаагүй.

5. Санхүүгийн тайлангийн аж ахуйн материал 29745280.28 төгрөг, няравын тайлан 21414739 төгрөг 8330541.28 төгрөгөөр, бичиг хэргийн санхүүгийн тайланд 1933180 төгрөг, няравын тайланд 948680 төгрөг 984500 төгрөгийн тус тус зөрүүтэй байна.

6. Шилэн дансны тухай Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан журмын 2.2.3.2 зээл, өрийн бичиг бонд, зээл өрийн бичиг, баталгаа түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр мэдээлэлд 2021 онд хөрөнгө мөнгө зарцуулах 18 шийдвэр гарсанаас 7-ыг мэдээлж 11 тушаал мэдээлээгүй. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ цэсэнд 1-ээс 12 сард байхгүй гэж мэдээлсэн. Хагас жилийн санхүүгийн тайлан цэсэнд мөнгөн гүйлгээний тайлангийн эхний нүүрийг мэдээлсэн зэрэг зөрчилүүд илэрлээ.

АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 актаар 69.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, албан шаардлага бичиж, 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

ДҮГНЭЛТ

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 14.4.2, 14.4.3, 20.1.4, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийлтэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар"-ын хэрэгжилт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. .

АРВАН НЭГ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 сарын 30-ны өдрийн 390 тоот тушаалын 1 дүгээр хавсралт Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөж ажиллах.

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж, гүйцэтгэлийг хянан баримтжуулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам албан бичгээр ирүүлэх.

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажилз охион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлэх.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

УЛСЫН БАЙЦААГЧ

Л.ЦЭРЭНБҮТЭД